



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/489

Булган сум

┌ Аймгийн баяр наадмын төсөв батлах тухай ┐

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоол, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, Соёл урлагийн газар, Биеийн тамир, спортын улсын хорооны хамтарсан А/237, А/76, А/604 дугаар тушаал, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 104 жилийн ой, Булган аймаг байгуулагдсаны 87 жилийн ой, аймгийн баяр наадмын хурдан морины уралдаан 3 өдөр болсонтой холбогдуулан нэмэлтээр шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

2. Баяр наадмын арга хэмжээний нэмэлт зардал 11,677,000 (арван нэгэн сая зургаан зуун далан долоон мянга) төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд)-т зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны  
07 дугаар сарын 08 -ны/ний өдрийн  
0.А.185 дугаар захирамжийн хавсралт

Үндэсний баяр наадам, Ардын хувьсгалын 104 жилийн ой,  
Булган аймаг байгуулагдсаны 87 жилийн ойн баяр наадмын төсөв

д/д	Зориулалт, арга хэмжээ	Ирүүлсэн санал /мян.төг/	Хянасан төсөв /мян.төг/
1	2	3	4
1	Үндэсний бөхийн барилдаан	2,500.000	2,500.000
2	Хурдан морины уралдаан	3,572.000	3,572.000
3	Үндэсний сурын харваа		
4	Үндэсний шагайн харваа		
5	Нийгмийн хэв журам сахиулах арга хэмжээ	3,015.000	3,015.000
6	Хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, орчны ариун цэврийн шаардлага хангуулах	490.000	490.000
7	Нийгэм, соёл, урлагийн арга хэмжээний зардал		
8	Аж ахуйн зардал	2,100.000	2,100.000
9	Хэвлэл мэдээлэл, сурталчилгаа		
10	Гадаад зочин төлөөлөгчийн зардал		
11	Засвар, тохижилтын ажил		
	<b>Дүн</b>	<b>11,677.000</b>	<b>11,677.000</b>